

4. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат иргэний нас барсны дараа улдсэн бух хөдлөх эд хөрөнгө хэрэв Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байгаа бол бух өв залгамжлагчдын зөвшөөрөл, өв залгамжлагч буюу хувь авагчийн хусэлтээр Хэлэлиэн Тохирогч Этгээдийн байгууллага уг өв залгашслах хэргийг авч хэлэлиэнэ.

Дөчин долдугаар зүйл

Ямар эд хөрөнгийг хөдлөх, ул хөдлөх гэж үзэхийг эд хөрөнө з нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч Этгс =>-дийн хуулиар тогтсоно,

Дөчин наймдугаар зүйл

Нас барсныг мэдэгдэх

1. Хэрэв Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэюгэрт Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат нас барвал, - нас барсан тухай болон өв залгамжлагч, тэдний байнга буюу/ тур оршин суугаа газрын хаяг өвлөх хөрөнгийн хэмжээ, гэрээслэл уйлдсэн зээх талаар мэдэж байгаа зүйлээ тэр Этгээдийн эрх бүхий байгууллагаас нас барагчийн харьяалагдах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шууд яаралтай мэдэгдэнэ. Хэрэв энэ байгууллага нас барагчийн үлдээсэн еэр улсад байгаа эд хөрөнгийн талаар мэдэж байгаа бол энэ тухайгаа бас мэдэгдэнэ.

2. Хэрэв өв залгамжлалын хэргийг хэлэлцэж байгаа байгууллага, өв залгамжлагч Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат мөн болохыг тогтоовол тэрхуу Хэлэлцэн Тохирогч Этгээдийн дипломат тэлөөлөгчийн буюу консулын газарт энэ тухайгаа мэдэгдэх уурэгтэй.

3. Хэрэв дипломат тэлөөлөгчийн буюу консулын иззар нас барсныг эхэлж мэдвэл өвлүүлэх хөрөнгийг хамгзалах зорилг:ор өв залгамжлалын хэргийг авч хэлэлцэх эрх бүхий байгууллагад мэтэгдэнэ